



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 342

Улаанбаатар хот

Маргаан таслах зөвлөл байгуулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88.1, Хорооны 2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 337 дугаар тогтоолоор батлагдсан “Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагчийн хооронд гарсан маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий орон тооны бус Маргаан таслах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/ Маргаан таслах зөвлөлийн дарга:

Х.Бум-Эрдэнэ

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга;

2/ Гишүүд:

Т.Жамбаажамц

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч;

О.Батбилэг

Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн хэлтсийн дарга;

Ж.Нарантуяа

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хяналтын албаны ахлах мэргэжилтэн;

Э.Дамдиндорж

“ҮЦТТХТ” ХХК-ийн хуулийн зөвлөх;

Б.Алтанбаяр

МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн;

000407

Д.Дүгэржав

“MDS & Khanlex” ХХК-ийн партнер;

3/ Нарийн бичгийн дарга:

Ц.Цэрэнтогтох

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт
цаасны газрын хянан шалгагч.

2. Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааг удирдан явуулж, холбогдох шийдвэрийг Хорооны хуралдаанд танилцуулж ажиллахыг Маргаан таслах зөвлөл /Х.Бум-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН